

## I. ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Компани 2018 онд 12 төсөвт байгууллага, 128 аж ахуйн нэгж, 1134 айл өрх, нийт 1273 хэрэглэгчтэй ус, дулааны эрчим хүчээр хангаж, бохир ус татан зайлуулах гэрээ байгуулан ажилласан.

### 1. Дулааны эрчим хүч

Тайлант онд 41.2 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэхээс 37.7 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэн 91.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь 2018 онд үйлдвэрлэсэн дулааны эрчим хүчийг тоолуураар тооцож эхэлснээс, мөн ШГХК-ийн нүүрс угаах үйлдвэр ДЭХ авахгүй болсон зэргээс шалтгаалан үйлдвэрлэлийн төлөвлөгөө 3.6 мян.Гкал-аар тасарсан.

Зуны улирал буюу 5.15-9.15 хүртэл 4 сар 1 зуух галлан орон сууцны хэрэглэгчдийг тасралтгүй хэрэгцээний халуун усаар ханган 593 тн нүүрс шатааж 1.2 мян.Гкал дулааны эрчим хүчийг үйлдвэрлэсэн.

Сүлжээний нэмэлт усны зарцуулалт төлөвлөгөөнөөс 2.6 мян.м<sup>3</sup>-ээр буурч 26.1 мян.м<sup>3</sup> гарсан байна. Усны алдагдалтай холбоотой дуудлагыг хүлээн авч шуурхай барагдуулан, дулаан дамжуулах сүлжээ, түгээх сүлжээнд гарсан гэмтлийг шуурхай устгаж, түгээх шугамын шинэчлэлийн ажлыг үе шаттай хийж байгаа зэргээс шалтгаалан нэмэлт усны алдагдал багассан. Мөн Сумын хуучин тосгоны 2 давхар байрууд нь хэрэгцээний халуун усны шугамгүй учир хэрэглэгчид сүлжээний усыг зүй бусаар ашиглаж нэмэлт усны зарцуулалтыг ихэсгэдэг байдалд хяналт тавьж хэрэглэгчдээр эргэлт, ухуулга сурталчилгаа хийх, системд тавьсан крантыг авч заглушка тавих зэрэг ажил зохион байгуулан ажилласан. Сүлжээний нэмэлт усны цагийн зарцуулалт 3-5м<sup>3</sup>/ц болон буурсан. Технологийн давс 24.7 тонныг хэрэглэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3.3 тонн буюу 13.5 хувиар буурсан байна.

### 2. Ус хангамж, ариутгал татуурга

470.5 мян.м<sup>3</sup> ус олборлохоос 422.1 мян.м<sup>3</sup> ус олборлон 89.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь усны тоолууржилтаас шалтгаалан зохистой хэрэглээ нэмэгдэж байгаа, мөн нүүрс угаах үйлдвэр ажиллахгүй байгаагаас ШГХК-ийн усны хэрэглээ буурсан зэргээс шалтгаалсан байна.

Одоогийн байдлаар төсвийн байгууллагын 67 хувь, бусад аж ахуй нэгж 82 хувь, айл өрхийн 75 хувь нь цэвэр усны тоолууржилтанд хамрагдсан байна. Энэ онд 83 айл өрх, 6 аж ахуй нэгжид нийт 196 ширхэг тоолуур шинээр суурилуулсан.

361.3 мян.м<sup>3</sup> бохир ус татан зайлуулахаас гүйцэтгэлээр 342.4 мян.м<sup>3</sup> бохир усыг татан зайлуулсан байна.

**Үндсэн үйлдвэрлэлийн үзүүлэлтүүдийг мөн үетэй харьцуулан хүснэгтээр  
үзүүлбэл:**

№	Нэр	Хэмжих нэгж	2017	2018		зөрүү	
			гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	өмнөх оноос	төлөвлөгөөнөөс
1	Үйлдвэрлэсэн ДЭХ	мян.Гкал	39.8	41.3	37.7	-2.1	-3.6
2	Дотоод хэрэглээ	мян.Гкал	2.9	3.2	3.2	0.3	-
3	Түгээсэн ДЭХ	мян.Гкал	36.9	38.1	34.5	-2.4	-3.6
4	Нүүрс	мян.тн	13.2	14.5	14.3	1.1	-0.2
5	Нэмэлт ус	мян.тн	25.2	28.7	26.1	0.9	-2.6
6	Давс	мян.тн	22.2	24.7	21.4	-0.8	-3.3
7	Цэвэр ус	мян.тн	448.3	470.5	422.1	-26.2	-48.4
8	ЦЭХ-ний хэрэглээ	мян.кВт	2 117.5	2 343.9	2 266.4	148.9	-77.5

Эрчим хүчний хэмнэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд тайлант онд 2.343,9 мян.кВт ЦЭХ хэрэглэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2.266,4 мян.кВт хэрэглэн 77,5 мянган кВт цахилгаан эрчим хүч буюу 9.2 сая төгрөгийн хэмнэлт гарган ажилласан.

Сүлжээний усны насос, ус өргөх насосуудад давтамж хувьсгуур суурилуулснаар усны хэрэглээ, ачаалалд тохируулан ажиллагааны ашигтай горимыг тогтоон насосуудыг хувьсах горимоор ажиллуулж ЦЭХ-ний хэрэглээг тодорхой хувиар бууруулан ажиллаж байна.

Мөн байгууллагын хэмжээнд хэсэг нэгж бүрт цахилгаан эрчим хүчний хэрэглээг багасгах ажил зохион байгуулах, гэрэлтүүлгийг шинэчлэх ажлын хүрээнд ажлын байруудаар улайсах ламп хэрэглэдэг байсныг мэдрэгчтэй гэрэл, LED гэрлээр сольсон.

Хэрэглэгчдээс нийт 1486 дуудлага хүлээн авч шуурхай барагдуулан ажилласан. Ажил үйлчилгээний орлого 5.300,3 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.


Дуудлагыг төрлөөр нь ангилвал:

Дуудлагын төрөл	х.н	Халаалт	Хэрэгцээний халуун ус	Цэвэр ус	Бохир ус	Тоолуур	Бусад	Бүгд
2018 он	тоо	168	101	418	313	194	292	1486

## II. САНХҮҮ БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант онд борлуулалтын орлогыг 49.7 сая төгрөгөөр илүү төвлөрүүлэн, 454.5 сая төгрөгийн санхүүжилт авч, зардлыг 112.5 сая төгрөгөөр хэмнэн, 45.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж төлөвлөгөөт алдагдлыг 116.8 сая төгрөгөөр, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлыг 0.07 нэгжээр бууруулан ажилласан байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Нийт зардал	3,281.4	3,268.9	(112.5)	96.6
Нийт орлого	2,619.6	2,669.3	49.7	101.9
Санхүүжилт	500.0	454.5	(45.5)	90.9
Алдагдал	(161.8)	(45.0)	116.8	27.8
БО-ын 1 төгрөгт ногдох зардал	1.25	1,19	(0.07)	94.8




### 1. Борлуулалт

Үндсэн үйл ажиллагаанаас 2 465.0 сая төгрөгийн борлуулалт хийх төлөвлөгөөтэй байснаас 2 450.0 сая төгрөгийн борлуулалт хийж борлуулалтын төлөвлөгөөг 99.4 хувиар биелүүлжээ. Нийт борлуулалтын 36.5 хувийг төсвийн газарт, 50.6 хувийг аж ахуйн нэгж байгууллагат, 12.6 хувийг орон сууцны айл өрхөд, 0.3 хувийг гэр хорооллын айл өрхүүдэд тус тус борлуулсан.

Борлуулалтын төлөвлөгөөгөөр 176.5 сая төгрөгийн цэвэр ус борлуулахаас 171.6 сая төгрөг буюу 97.2 хувь, 147.9 сая төгрөгийн бохир ус татан зайлуулалт төлөвлөснөөс 130.1 сая төгрөг буюу 88 хувь, 2 067.5 сая төгрөгийн дулааны эрчим хүчний борлуулалт хийхээс 2 052.8 сая төгрөг буюу 99.3 хувь, 73.0 сая төгрөгийн хэрэгцээний халуун усны борлуулалт төлөвлөснөөс 95.5 сая төгрөг буюу 130 хувиар тус тус биелүүлжээ.

## Борлуулалтын бүтэц

**2. Орлогын талаар**

Тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 2 450.0 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлэх ёстойгоос 2 491.9 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлж борлуулалтын орлогын төлөвлөгөөг 1.7 хувиар давуулан биелүүлсэн.

**Орлогын бүтцийг авч үзвэл:**

Дулааны орлого сая төгрөг буюу 2.2 хувиар давж, бохир ус сая төгрөг буюу 3.2 хувь, цэвэр ус сая төгрөг буюу 12.5 хувь, ХХУс сая төгрөг буюу 5,9 хувиар тус тус дутуу төвлөрүүлсэн байна.

Үндсэн бус үйл ажиллагааны орлого төлөвлөгөөгөөр 154.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 219.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 141,9 хувиар давуулан биелүүлсэн байна.

сая.төг

№	Бүтээгдэхүүн	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<i>Үндсэн үйл ажиллагааны орлого</i>					
1	Цэвэр ус	176.5	171.6	(4.9)	97.2
2	Бохир ус	147.9	130.1	(17.8)	88
3	Халаалт	2,067.5	2,052.8	(14.7)	99.3
4	Хэрэглээний халуун ус	73.0	95.5	22.5	130.8
<b>Дүн</b>		<b>2,465.0</b>	<b>2,450.0</b>	<b>15.0</b>	<b>99.4</b>
<i>Үндсэн бус үйл ажиллагааны орлого</i>					
1	Усны суурь хураамж	31.9	33.2	1.3	104
2	Засвар, ажил үйлчилгээ	5.0	23.6	18.6	472
3	ТАА-н орлого	16.2	11.7	4.5	72.2
4	Хуучин турба, лотки худалдан борлуулсны орлого	101.5	119.4	17.9	117.6
5	Бусад		31.4	31.4	100
<b>Дүн</b>		<b>154.6</b>	<b>219.3</b>	<b>64.7</b>	<b>141.9</b>
<b>Нийт орлого</b>		<b>2,619.6</b>	<b>2,669.3</b>	<b>49.7</b>	<b>101.9</b>

**3. Зардлын талаар**

Нийт 3 281.4 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөн гүйцэтгэлээр 3 168.9 сая төгрөгийн зардал гаргаж 112.5 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар хэмнэсэн байна.

№	Зардлын төрөл	Өссөн дүн		Зөрүү		Зардалд эзлэх хувь
		төлөв	гүйц			
1	Цалин	1 191,7	1 151,3	(40,4)	96,6	36,3
2	НДШимтгэл	154,9	161,7	6,7	104,4	5,1
<b>ДҮН</b>		<b>1 346,6</b>	<b>1 313,0</b>	<b>(33,6)</b>	<b>97,5</b>	<b>41,4</b>
3	Урсгал засвар	65,5	64,3	(1,2)	98,2	2,0
4	Хангамжийн материал	18,9	13,6	(5,3)	71,9	0,4
5	Туслах материал	10,3	7,5	(2,7)	73,4	0,2
6	Цахилгаан эрчим хүч	387,1	377,9	(9,2)	97,6	11,9
7	Дотоод хэрэгцээ	157,9	161,1	3,2	102,0	5,1
8	Нүүрс	530,6	536,4	5,8	101,1	16,9
9	ТУЗ-ийн зардал	50,5	50,5	-	100,0	1,6
10	Холбоо	5,1	4,4	(0,7)	86,3	0,1
11	Бичиг хэрэг	6,1	4,9	(1,2)	81,0	0,2
12	Албан томилолт	9,7	3,6	(6,2)	37,1	0,1
13	ҮХ-н элэгдэл	281,3	275,0	(6,3)	97,8	8,7
14	Хөдөлмөр хамгаалал	46,2	34,5	(11,6)	74,8	1,1
15	Шатахуун түлш, тос	38,9	38,7	(0,2)	99,5	1,2
16	Дээж шинжилгээ	1,9	1,7	(0,2)	89,7	0,1
17	ҮХХ-н татвар	24,2	23,4	(0,8)	96,8	0,7
18	Газрын татвар	1,3	1,2	(0,1)	85,5	0,0
19	АТӨЯХ-н татвар	0,6	0,4	(0,2)	68,5	0,0
20	Усны нөөц ашиг. татвар	3,1	1,9	(1,2)	60,6	0,1
21	Бусдаар гүйц.ажил	52,2	50,9	(1,3)	97,5	1,6
22	Нийгэм САХэмжээ	74,8	47,6	(27,2)	63,6	1,5
23	Сургалт	15,0	9,3	(5,7)	62,0	0,3
24	Хэвлэл захиалга	0,5	0,3	(0,2)	58,2	0,0
25	Сэлбэг хэрэгсэл	19,9	19,1	(0,8)	96,3	0,6
26	Гүйцэтгэх удирдлагын зардал	79,9	78,7	(1,2)	98,4	2,5
27	Байгаль орчны нөлөөлөл	2,5	1,5	(1,0)	62,0	0,0
28	Усны зардал	38,7	35,2	(3,5)	91,0	1,1
29	Бусад зардал	11,6	11,7	0,1	101,2	0,4
<b>Нийт зардлын дүн</b>		<b>3 281,4</b>	<b>3 168,9</b>	<b>(112,5)</b>	<b>96,6</b>	

**Хэмнэсэн зардлыг талаар**➤ *Цалингийн зардал*

2018 онд төлөвлөсөн цалингийн зардлыг 9 орон тоо дутуу ажиллаж 59.8 сая төгрөг, сарын үр дүгнийн шагналыг дунджаар 35 хувиар олгохоор төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 27,4 хувиар олгож 73.2 сая төгрөг нийт 133 сая төгрөгийн хэмнэлт гаргаж 12-р сард цалинг 50,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэхэд 7,3 сая төгрөг, жилийн үр дүнгийн урамшуулалд 85,3 сая төгрөг тус тус олгож 40,4 сая төгрөгөөр хэмнэлт гарган ажилласан.

2017 оны жилийн үр дүн урамшуулалд 38,6 сая төгрөг тайлант оны 2 дугаар сард, 2018 оны жилийн үр дүн урамшуулалд 85,3 сая төгрөгийг тайлант оны эцэст олгосон.

№	Зардлын төрөл	2016 он	2017 он	2018 он		Зөрүү	Хувь
				төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	Цалин	867,6	991.3	1,191.7	1,151.3	(40,4)	96,6
2	НДШимтгэл	107,3	128.4	154,9	161,7	6,8	104,3
<b>Нийт цалин</b>		<b>974,9</b>	<b>1,119.7</b>	<b>1,346.5</b>	<b>1,313.0</b>	<b>(33,3)</b>	<b>97,5</b>
<b>Сарын үр дүн</b>		<b>98,5</b>	<b>121,4</b>	<b>233,3</b>	<b>160,1</b>	<b>73,2</b>	<b>68,6</b>
<b>Жилийн үр дүн</b>		<b>18,3</b>	<b>23,9</b>	<b>32,6</b>	<b>123,9</b>	<b>91,3</b>	<b>379</b>

- *Цахилгааны зардал*: Биет хэмжээгээр 77,5 мян. кВт/ц буюу 9,2 сая төгрөгөөр хэмнэлт гаргасан.
- *Албан томилолт*: 6,1 сая төгрөг хэмнэсэн нь гадаад томилолтоор хэмнэгдсэн.
- *Шатахуун*: Шатахууны үнэ дунджаар 28 хувиар нэмэгдсэн хэдий ч ажилчдын автобус болон удирдлагын автомашин дээр хэмнэлт гарсан..

**Зардлыг хэтрүүлсэн шалтгааны талаар**

- *Түлшний зардал*: 2018 онд дулаан үйлдвэрлэхэд 14,510 тн нүүрс шатааж 530,6 сая төгрөгийн түлшний зардал гаргахаас төлөвлөн гүйцэтгэлээр 14,265 тн нүүрс шатааж биет хэмжээгээр хэмнэсэн боловч Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 286 тоот тогтоолоор нүүрсний үнэ 2000 төгрөгөөр нэмэгдэж түлшний зардал 536,4 сая төгрөг болон 5,8 сая төгрөгөөр хэтэрсэн байна.
- *Дотоод хэрэгцээ*: Дулааны станцын дотоод хэрэглээний цэвэр усанд тоолуур сууриллуулснаар бодит хэрэглээг тооцсноор нэмэгдсэн.

**4. Бүтээгдэхүүн өөрийн өртгийн талаар**

ДЭХ-ний өөрийн өртөг 3,8 мян.төгрөгөөр нэмэгдсэн нь дулаан үйлдвэрлэлт буурч, түлш, шатахууны үнэ нэмэгдэж холбоотой байна. Борлуулалтын өртөг төлөвлөгөөнөөс 5,0 мян.төгрөгөөр нэмэгдсэн нь хэдийгээр дулаан үйлдвэрлэл

буурсан ч шинээр 48 айлын орон сууц , сурагчдын дотуур байр ашиглалтанд орж дулааны борлуулалт нэмэгдсэнтэй уялдан нэгж бүтээгдэхүүнээс 1,0 мянган төгрөгийн ашигтай ажилласан.

Цэвэр усны өөрийн өртөг 70 төгрөгөөр буурсан нь БОШХ буурсантай холбоотой, борлуулалтын өртөг 20 төгрөг болж буурсан нь задгай хэрэглэгч тоолууржсанаар үнийн зөрүү гарсантай холбоотой, нэгж бүтээгдэхүүнд 50 төгрөгийн алдагдалтай.

Бохир усны өөрийн өртөг 20 төгрөгөөр буурсан нь БОШХ буурсантай холбоотой, борлуулалтын өртгийг 30 төгрөг болж буурсан нь задгай хэрэглэгчид тоолууржсанаас үний зөрүү гарсантай холбоотой, нэгж бүтээгдэхүүнд 10 төгрөгийн алдагдалтай тус тус ажилласан байна.

Үзүүлэлт	Х.Н	ДЭХ			Цэвэр ус			Бохир ус		
Бүтээгдэхүүн	мян.гкал/ м <sup>3</sup>	41,3	37,7	3,6	470,5	422,1	48,4	339,2	342,4	3,2
Өөрийн өртөг	мян.төг	64.0	67,8	3.8	1.21	1,14	(0.07)	0.56	0,54	(0.02)
Борлуулж буй	мян.төг	51.1	56,1	5.0	0.51	0,49	(0.02)	0.41	0,38	(0.03)
Алдагдал нэгж бүтээгдэхүүнд	мян.төг	(12.7)	(11,7)	1.0	(0.7)	(0,65)	(0.05)	(0.15)	(0,16)	(0.01)

### 5. Авлагын талаар:

сая.төг

№	Авлагын төрөл	2017.12.31	2018.12.31	Өсөлт бууралт(+/-)	Тайлбар
	Төсөв	2.7	2,7	0	Энигма констракшн /Дотуур байр/
2	ААНэгж	218.6	198,3	(20,3)	Аж ахуйн нэгж байгууллагуудтай тооцоо нийлж, төлөлтийн график мөрдөж ажилласан.ШГХК-н тооцоо орсон /178,0 сая/
3	Орон сууц	122.9	113,4	(9,5)	Байцаагч нар айл өрх бүртэй тооцоо хийж, төлөлтийн график мөрдөж ажилласан.
	<b>Дүн</b>	<b>344.2</b>	<b>314,4</b>	<b>(24,7)</b>	
4	Байгууллага хоорондын тооцоо	0.02	0	<b>0,02</b>	Аж ахуйн нэгж байгууллагуудтай тооцоо нийлж, төлөлтийн график мөрдөж ажилласан.
5	Хувь хүмүүс, ажилчдаас авах авлага	0.008	0	<b>0.008</b>	Хувь хүмүүс,ажилтнуудтай тооцоо хийж, төлөлтийн график мөрдөж ажилласан.
6	Бусад авлага	12.2	12.2	<b>0</b>	
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>356.4</b>	<b>326,6</b>	<b>-29,9</b>	

**Тайлант онд:**

1. Орон сууцны хэрэглэгчдийн авлага 9,5 сая.төгрөгөөр
2. Аж ахуйн нэгж байгууллагуудын авлага 20,3 сая төгрөгөөр буурсан байна. ШГХК-ний 178,0 сая төгрөгийн авлагыг авахаар ШШГазар болон гэрээт өмгөөлөгчтэйгээ хамтран ажиллаж байна.
3. Харилцагч бусад байгууллага болон хувь хүмүүс, ажилтнуудаас авах авлагын тооцоог ажил үйлчилгээ, гүйлгээ гарсан тухай бүр санхүүгийн тайланд тусган, тооцоо нийлж, дараа тайлангийн гүйцэтгэлийг хугацаанд нь гаргуулан ажиллан нийт авлагыг 29,9 сая төгрөгөөр бууруулсан үзүүлэлттэй байна.

Цаашид авлага барагдуулах ажлыг эрчимжүүлж, харилцагчидтай тооцоо нийлэн тодорхой хугацаанд төлбөрөө төлөх гэрээ байгуулан, хугацаа хожимдсон тохиолдолд алданги тооцох, барагдуулаагүй бол таслалт хийх зэргээр харилцан тохиролцож албан мэдэгдэл хүргүүлэн мөн ШШГүйцэтгэгч болон гэрээт өмгөөлөгчтэйгээ хамтран ажиллаж байна. Ажлын үр дүнг борлуулалтын орлогын байцаагч нарын цалин урамшуулалтай уялдуулсан журмыг боловсруулан мөрдөн ажиллаж байна.



**6.Өглөгийн талаар:**

сая.төг

№	Байгууллагын нэр	Үлдэгдэл		Өсөлт бууралт (+-)	Тайлбар
		эхний	эцсийн		
1	ДСЦТС ХК	647.0	573,9	-73,1	Цахилгааны төлбөрт тайлант онд 483,9 сая төг төлсөн
2	Дархан ДЦС ТӨХК	209.1	209.1	-	2010 онд менежментийн гэрээгээр нийлүүлсэн сэлбэгийн төлбөр
3	УБ Тэнхлэг -Ус ХК	2.5	2.5	-	2009 оноос өмнө үүссэн
4	ҮЭХороо ДШГ	2.7	1.9	-0,7	Цалингаас ҮЭ татвар
5	ШУТИС-ЭХИС	0.46	0.46	-	2013 онд авсан Эрчим хүч инженер сэтгүүлийн үнэ
6	УБ Трансинконсулт ХХК	0.25	0.25	-	2013 онд авсан материалын үнэ
7	ДЭМТ ХХК	1.6	1.6	-	2013 онд авсан сандлын үнэ
8	Татвар	207.4	284,9	77,5	тайлант хугацаанд 343,4 сая төг төлсөн
9	Нийгмийн даатгал	154.6	118,5	-36,1	НДШимтгэлд тайлант онд 301,8 сая төг төлсөн
10	Цалингийн өглөг	-	67,9	67,9	Ажиллагсдын жилийн үр дүнгээр
11	Да Мэргэжлийн хяналтын газар	0.2	0.3	0.1	2017 онд актаар тавигдсан
12	Ажилчид, Хувь хүмүүст өгөх өглөг	2.7	0,9	-1,8	Ухаалаг худаг, гэрээт ажлын төлбөр
13	Вест Сайз констракшн	3.5	3.5	-	Дохиолол хамгааллын төхөөрөмж
14	Халиун ШГ ХХК	4.5	-	-4.5	Шатахууны тооцоо
15	Од ктв	0.1	-	-0.1	Зар суртчилгааны төлбөр
16	Ажилчидын фонд өглөг	3.3	-	-3,3	Цалингаас суутгасан
17	МЭЗ ХХК	17.8	4,8	13,0	Гэрээт засварын тооцоо
18	Альянс Тех ХХК	3.5	-	-3.5	Материалын үнэ/актуаторын /
19	Галакси Экспеишин ХХК	4.0	-	-4.0	Борлуулалтын программын төлбөр
20	Ногоон Хайрцаг ХХК	5.0	-	-5.0	Хөдөлмөр хамгааллын хувцасын төлбөр
21	Новатек Интернэшнл	61.2	-	-61.2	Трубаны үнэ
22	Мянган Ватт ХХК	0.4	-	-0.4	Материалын үнэ/аварын гэрэл/
23	Сэтгэлд шингэсэн үйл ББН	1.4	-	-1.4	Материалын үнэ /бээлий/
24	Халиугчин Батдэлгэр ХХК	3.5	-	-3.5	Материалын үнэ/төмөр тор/
25	Гасба ХХК	10.0	1.0	-9.0	Давтамж хувьсгуурын баталгаат хугацааны барьцаа
26	Престиж Электрик ХХК		16,0	16,0	Сүлжээний усны насосны үнэ
27	Гоулден Резин ХХК		13,0	13,0	Ус хийжүүлэх төрөөрөмж
28	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн		9,5	9,5	Эрчим хүчний аудитын төлбөр
29	Түвшин Ретро ХХК		0,18	0,18	Сэлбэгийн үнэ /Опор/
30	Монгол Удам констракшн		23,0	23,0	Автобусны үнэ
31	Билэг Дизайн ХХК		8,8	8,8	Хөдөлмөр хамгааллын хувцасын төлбөр
27	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв		0.8	0.8	Хадгаламжийн үйлчилгээний төлбөр
<b>НИЙТ ДҮН</b>		<b>1,346.7</b>	<b>1,342,9</b>	<b>-3,8</b>	

**Тайлант онд:**

1. Нийт өр төлбөрийн дүн 3,8 сая төгрөгөөр буурсан.

Нийгмийн даатгалын шимтгэлд 310,7 сая төгрөгийн ноогдуулалт хийгдэж 301,8 сая төгрөг төлж өр төлбөр 36,1 сая төгрөгөөр, тайлант онд 377,2 сая төгрөгийн ЦЭХ хэрэглэж, 483,9 сая төгрөг төлж 73,1 сая төгрөгөөр тус тус буурч, татварт нийт 422,6 сая төгрөгийн ноогдуулалт хийснээс орон нутгийн болон бусад татварыг бүрэн барагдуулж НӨАТ-ын өр төлбөр 77,5 сая төгрөгөөр өссөн байна.

Цаашид өр төлбөрийн судалгаа гарган, мөнгөн хөрөнгийн урсгалыг оновчтой тооцоолон, хуваарь хийн үе шаттайгаар барагдуулахаар ажиллаж байна.

**Халаалтын бус улиралд хэрэгцээний халуун ус өгөх өгөөж:**

Хэрэгцээний халуун ус өгдөг болсноор зардал 13,6 хувиар нэмэгдэж, орлого 20 хувиар өссөн байна.

Үзүүлэлт	2018.12.31 байдлаар	Төлбөр барагдуулах боломж
Эргэлтийн хөрөнгө	482.3	35.9хувь
Мөнгөнхөрөнгө	0.2	0.0хувь
Авлага	326.6	24.3хувь
Бараа материал, бусад	155.5	11.6хувь
Богино хугацаат өр төлбөр	1,342.9	
Зөрүү	(860.6)	64.1хувь

Богино хугацаат өр төлбөрийн 64.1 хувийг эргэлтийн хөрөнгийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжтой. Төлөх эх үүсвэргүй 860.6 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

**7. Худалдан авалтын талаар**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 3 дугаар тогтоолоор худалдан авалтын төлөвлөгөөг 384,75 сая төгрөг байхаар батласан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 321 дүгээр тогтоолоор Дулаан Шарын гол ТӨХК-ний 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан ба Дулаан Шарын гол ТӨХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор компаний 2018 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулснаар 626,25 сая төгрөг болсон. Худалдан

авалтын төлөвлөгөөг цаг тухай бүрт нь TENDER.GOV.MN сайтад дэлгэрэнгүй байршуулж худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжид нийцүүлэн ажилласан. 2018 оны гүйцэтгэлээр 583,9 сая төгрөгийн худалдан авалт хийж 93,2 хувь байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан Нээлттэй тендер шалгаруулалт 2, харьцуулалтын аргаар худалдан авах 6, зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт 1 нийт 9 ажлыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу зохион байгуулсан. Үүнээс Сүлжээний усны насос худалдан авах 60,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа TENDER.GOV.MN сайтад урилгыг нийтлэн зарласан боловч оролцогч тендер ирүүлээгүй бөгөөд хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэн 34.3-т заасны дагуу гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.

Харьцуулалтын аргаар худалдан авах бараа, ажил үйлчилгээ болох "Ажлын хувцас, гутал", "Түлш шатахуун", "Автобус худалдан авах", "Ухаалаг худаг, шугам шинээр барих", "Дулааны станцын дээвэр, дотоод заслын ажил" зэрэг 5 ажлыг 2 удаа цахимд урилгыг нийтлэснээр оролцогч үнийн санал ирүүлж гэрээ байгуулсан. "Ус хийгүүжүүлэх төхөөрөмж /төмрийн үртсэн деаэратор/ суурилуулах" ажил 2 удаа зарлан амжилтгүй болсон тул нэмэлт өөрчлөлтөөр үнийг нэмэгдүүлж 3 дахь удаад үнийн санал авах урилгыг цахимд байршуулж урд жилүүдэд ойролцоо төрлийн тоног төхөөрөмж нийлүүлж байсан "Голден Резин" ХХК, "МЭЗ" ХХК, "ГАСБА" ХХК зэрэг компаниудад үнийн санал авах урилгыг албан бичгээр илгээж "Голден Резин" ХХК үнийн санал ирүүлснээр гэрээ байгуулсан.

Зуухны засварын сэлбэг, материал худалдан авах ажил нь 8,3 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 3,4 сая төгрөгийн худалдан авалт хийгдсэн. Өрлөг дулаалгын материал худалдан авах ажил 3,4 сая төгрөг төлөвлөгдсөн боловч шаардлагагүй болсон тул худалдан авалт хийгээгүй.

198,8 сая төгрөгийн шууд худалдан авалт хийхээр төлөвлөснөөс гүйцэтгэл 158,8 сая төгрөг байна. 40,1 сая төгрөгийн худалдан авалтын 31,7 сая төгрөгийн худалдан авалт нь хөрөнгө санхүүгийн дутагдлаас шалтгаалан хийгээгүйн болно.

Тайлант хугацаанд 10,6 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

мян.төг

№	Тендер шалгаруулалтын журам /арга/	Батлагдсан нийт төсөв	Гэрээний дүн	Хэмнэлт	Хийгдээгүй	Тендер шалгаруулалт ын тоо	Цахим тендер шалгаруулалт ын тоо
1	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	193 000,0	193 000,0	-		2	1
2	Харьцуулалтын арга	224 440,0	222 675,0	1 765,0		6	
3	Шууд худалдан авалт	198 810,0	158 763,0	8303,0	31 744,0		
4	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах журам	10 000,0	9 500,0	500,0		1	1
ДҮН		626 250,0	583 938,0	10 568,0	31 744,0	9	2

Худалдан авалтын төлөвлөгөө, Нээлттэй тендер шалгаруулалт, үнийн санал авах урилгыг TENDER.GOV.MN сайтад дэлгэрэнгүй байршуулан олон нийтэд мэдээлж, цахим болон уламжлалт аргаар зохион байгуулсан. Үүнээс Суудлын автомашин худалдан авах нээлттэй тендер шалгаруулалт болон Эрчим хүчний аудит хийлгэх зөвлөх үйлчилгээний тендерүүдийг тус тус цахим хэлбэрээр сонгон шалгаруулалт зохион байгуулсан.

Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийж гүйцэтгэн худалдан авах ажиллагааны хуулийн дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны явцад ямар нэг зөрчил, худалдан авах ажиллагааны талаар гомдол гараагүй.

## II. ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЫН ТАЛААР.

2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 25 багц ажил хийхээр төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа. Үүнд:

- ✓ Зохион байгуулалтын талаар 6 багц ажил төлөвлөж 100 хувь хийж гүйцэтгэсэн
- ✓ Техник тоног, төхөөрөмж ашиглалт засварын талаар 15 багц ажил төлөвлөсөн, гүйцэтгэл 100 хувьтай ажлууд бүрэн хийгдэж дууссан.
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, сургалтын талаар 4 багц ажил төлөвлөж 100 хувь хийж гүйцэтгэсэн байна.

### ИХ ЗАСВАР, ТЗБАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ.

Компанийн ТУЗ-ийн 2018.01.22-ны өдрийн 02 тоот тогтоолоор 2018 оны их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтаар 183.7 сая төгрөгийн 10 багц ажил хийгдэхээр төлөвлөгөөг батлуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн цэвэр усны шугам хоолой, Дулааны станцаас дулаан хуваарилах төв хүртэлх гадна цэвэр ус дулааны 2,2 км төв шугамын өргөтгөл шинэчлэлийн 4 253 280 132 (дөрвөн тэрбум хоёр зуун тавин гурван сая хоёр зуун наян мянга нэг зуун гучин хоёр) төгрөгийн өртөг бүхий ажлуудыг компаний үндсэн хөрөнгөд бүртгэх тухай шийдвэр гарч компанийн дүрмийн санг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан 2018 оны их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөгөөнд тодотгол оруулж, 11 багц ажлыг 383.7 сая төгрөгөөр хийхээр шийдвэрлүүлсэн.

2018 онд их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажилд 378.8 сая төгрөг зарцуулан төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 100 хувь хийгдсэн байна. Үүнд:

- Их засвараар 3 ажил 100 хувь хийгдэж, 70.7 сая төгрөгийг,
- ТЗБАХ-ээр 2 ажил 100 хувь хийгдэж, 48.8 сая төгрөгийг,
- Хөрөнгө оруулалтын 7 төрлийн ажил 100 хувь хийгдэж 259.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### УРСГАЛ ЗАСВАР:

Зуух, туслах тоноглол, шугам сүлжээний урсгал засварт 38 багц ажил хийхээр төлөвлөж, 64.3 сая төгрөгт зарцуулан 100 хувь хийж гүйцэтгэсэн.

## Компанийн 2018 оны ИЗ, ТЗБАХ, ХО-ын гүйцэтгэл

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/	зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Хөрөнг ийн хувь	гүйцэтгэл
<b>1.Их засвар</b>							
1	Дулааны станцын барилгын дээвэр /510м2/ засвар, дотор ажилчдын өрөөний засвар хийх	багц	1	45,317.6	45,226	100	100
2	218 -р конвейерийн ремень сольж, шанага шинэчлэх	багц	1	6,628.9	4,491	68	100
3	Ус түгээх ухаалаг худаг шинээр барих	багц	1	21,332.0	20,956.2	98	100
	<b>ДҮН</b>			<b>73,278.5</b>	<b>70,673.0</b>	96	<b>100</b>
<b>3. ТЗБАХ</b>							
1	Ус хийгүүжүүлэх төхөөрөмж/ төмрийн үртсэн деаэратор/ суурилуулах	багц	1	42,000.0	41,500.0	99	100
2	5-н давхар байрын халуун ус, хүйтэн усны тоолуур төвлөрүүлэлт	багц	1	8,507.0	7,270.5	85	100
	<b>ДҮН</b>			<b>50,507.0</b>	<b>48,770.5</b>	97	<b>100</b>
<b>2. Хөрөнгө оруулалтаар</b>							
1	Сүлжээний усны насос	багц	1	60,000.0	60,000.0	100	100
2	Компьютер	ш	1	6,000.0	5,450.0	91	100
	Нөүтбүүк	ш	2				
3	Сервер	багц	1	6,000.0	6,000.0	100	100
4	Санхүүгийн программ	багц	1	7,920	7,900.0	100	100
5	Суудлын машин	ш	1	133,000	133,000.0	100	100
6	Автобус	ш	1	47,000	47,000.0	100	100
	<b>ДҮН</b>			<b>259,920.0</b>	<b>259,350.0</b>	100	<b>100</b>
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>383,705.5</b>	<b>378,793.5</b>	99	<b>100</b>

**Техник дэвшлийн талаар**

1. Ус хийгүйжүүлэх төхөөрөмж / төмрийн үртсэн деаэратор/-ийг шинээр суурилуулан ашиглалтанд оруулсан.




2. Сүлжээний усны насосны хүчин чадлыг нэмэгдүүлэн шинээр насос суурилуулсан



3. 5-н давхар байрны хэрэгцээний халуун хүйтэн усны босоо шугам шинэчлэн, усны тоолуур төвлөрүүлэлтийн ажлыг 29 айлын нэг орон сууцанд хийж гүйцэтгэсэн.



4. Сумын гэр хорооллын иргэдийг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны цэвэр усаар тасралтгүй 24 цагаар хангах цахим худгийг өөрийн хөрөнгөөр барьж ашиглалтанд оруулсан.



"Дулаан Шарын гол" ТӨХК-ийн 2018 оны Ус түгээх худгийн ашиг алдагдал:

д/д	Үзүүлэлт	Ус түгээх зөөврийн худаг	Ус түгээх ухаалаг худаг
<b>Зардал</b>			
1	Цалин	22.62	-
2	НДШ	3.18	-
3	Цахилгаан	0.63	1.03
4	Шатахуун	5.02	-
5	Нүүрс	0.77	-
6	ХХ	0.08	
7	Сэлбэг хэрэгсэл	0.61	0.07
8	НСАХ	0.02	
9	Интернет		0.1
10	ДҮН	32.93	1.20
<b>Орлого</b>			
1	Ус	5.31	1.64
2	Карт	-	0.55
	ДҮН	5.31	2.19
	Зөрүү	-27.62	0.99
	<b>Ашиг алдагдал</b>	<b>-84%</b>	<b>83%</b>



5. Ажилчдын автобус, удирлагын автомашин шинээр худалдан авсан. Ингэснээр ажилчдыг ажилдаа аятай тухтай аюулгүй ирж явах, цаг ашиглалтыг сайжруулах асуудлыг шийдвэрлэж чадсан.



6. 218 дугаар конвейерын ременийг шинээр сольж найдвартай ажиллагаа сайжирсан.



7. К2 дугаар зуухны ул ширэмний засвар хийж, опор холхивч шинээр тааруулан угсарсан



**III. ХАБЭА, АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ТАЛААР :**

2018 онд компанийн нийт зардлын 1.1 хувь болох 34,5 сая төгрөгийг ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардалд зарцуулан ажилласан.

- Гэмтэл саатал, ослоос урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулан ажилласнаар технологийн зөрчилгүй ажилласан байна.
- Компанийн ажилчдын дунд аюулыг мэдээллэх хуудсыг ашиглан мэдээлэл өгч ажиллах журмыг шинэчлэн гаргаж батлуулан аюулыг мэдээллэх хуудсыг хэрэгжүүлэн нийт 78 аюулыг мэдээллэж, тухай бүр зөрчлийг устгах арга хэмжээг авч ажилласан.
- Нийт ажилчдыг “Буянтай” эмнэлэгтэй гэрээ байгуулан эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулсан.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хуулийн 18.1.2 дахь заалтын дагуу нийт ажилтнуудыг Практикал даатгалтай гэрээ байгуулан даатгалд хамруулсан.
- Аваари ослоос урьдчилан сэргийлж ажлын байрны I, II шатны үзлэгийг тогтмол хийж, III шатны үзлэгийг улирал бүр удирдлага болон ҮЭХ, ХАБЭА-н зөвлөлтэй хамтран зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан. III Үзлэгээр нийт 108 зөрчил илрүүлэн устгуулах арга хэмжээг авч ажилласан.

Монгол Улсын шадар сайдын 75-р тушаалыг үндэслэн Аймгийн Засаг даргын 2018 оны 01-А/83 дугаар захирамжийн дагуу Шарын гол суманд зохион байгуулах Гамшгаас хамгаалах “Иж бүрэн сургууль” 2018 оны 05 сарын 14-нөөс 05 сарын 18-ны өдрүүдэд дадлага, сургуулилт зохион байгуулагдсаны дагуу компанийн 13 хүний бүрэлдэхүүнтэй “Дулааны шугам сүлжээ, аваарь техникийн бүлэг” болон орон тооны бус штаб ажиллаж, амжилттай оролцон сайн үнэлгээ авсан.





Дулааны станцын дээврийн засварын ажлыг хэсэгчлэн шинэчилж дээврээс ус гоожилтыг зогсоосон.



Усны лабораторийн өрөөнд засвар хийж шинээр тохижуулсан



Дулааны станцад ажилчдын ахуйн өрөөг шинээр засвар хийж ашиглалтанд оруулсан.



---

**Сургалтын талаар :**

2018 онд мэргэжлийн байгууллагуудын болон дотоодод зохион байгуулах ажилтны чадавхижуулах сургалтанд 9,3 сая төгрөгийг зарцуулсан.

Үйл ажиллагааны чиглэлээр мэргэжлийн байгууллагуудаас зохион байгуулсан сургалтанд 70 ажилтан, ажилчдыг чадавхижуулах дотоодын сургалт 7 удаа зохион байгуулагдаж нийт ажилчид хамрагдсан. Суман дахь бусад мэргэжлийн байгууллага болох Шарын гол сумын цагдаагийн тасаг, ҮЭХ-н, бусад сургалтанд нийт давхардсан тоогоор 195 ажилтан, Шинээр ажилд орсон, өөр ажлын байранд шилжсэн ажилтны сургалтанд 24 ажилтан, мэргэжлийн зэрэг нэмэх сургалтанд 1 ажилтан тус тус хамрагдсан.

Үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж техник технологийн дэвшил, шинэ санаа оновчтой бүтээлийг сурталчлах, туршлага солилцох зорилгоор зохион байгуулсан өдөрлөгт нийт 12 ажилтан хамрагдсан.



## Бусад ажлын талаар

- Үйл ажиллагаанд ашиглагддаг дараах тусгай зөвшөөрлүүдийг сунгуулсан. Үүнд:
  - Дулаан үйлдвэрлэх, Дулаан түгээх, Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийг 5 жилээр,
  - 0.7-16.0 кгх/см<sup>2</sup> даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ хийх тусгай зөвшөөрлийг 3 жилээр,
  - Ус хангамж ариутгах татуургын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилээр
  - Усны тоолуур суурилуулах, засварлах тусгай зөвшөөрлийг 5 жилээр тус тус сунгуулав.

➤ Хот Суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 92 тоот тогтоолоор ЦЭВЭР, БОХИР УСНЫ үнэ, суурь хураамжийг шинэчлэн батлуулж, 2019 оны 01 сарын 01-нээс мөрдөн хэрэгжүүлж эхлэнэ.

➤ Жил бүр зохион байгуулагддаг “Усны өдөр”-ийг угтан хэрэглэгчдэд гарын авлага тарааж, орон нутгийн телевизээр “Усны зохистой хэрэглээ”-ний талаар сурталчилгаа явуулж ажиллалаа.

➤ Шарын гол сумын нээлттэй хаалганы өдөрлөгөөр компанийн үйл ажиллагааг сурталчлан, хэрэглэгчдийн дунд сугалаа явуулж 3 хэрэглэгчийг шалгаруулан шагнаж урамшуулсан.

➤ Дархан-Уул аймгийн СХЗХ-тэй гэрээ байгуулан хамтран ажиллаж баталгаат хугацаа нь дууссан айл өрх, ААНБ-ын тоолуурын баталгаажилт хийсэн. Үүнд

- 4 ААНБ - 6 ширхэг,
- 39 айл өрхийн 109 ширхэг тоолуур баталгаажилт хийгдсэн.

Нийт 115 ширхэг тоолуур баталгаажуулж 1 725 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

➤ Нийтийн аж ахуйн салбарын урлагийн их наадам, ижил төстэй байгууллагуудын болон Шарын гол сумаас зохион байгуулсан спорт урлагийн тэмцээн уралдаануудад амжилттай оролцсон.



➤ ҮЭХ-той хамтран ажилчдын хандиваар фитнесийн өрөөг шинээр байгуулан засвар хийж тохижуулсан.

➤ Шарын гол сумын хөрөнгө оруулалтаар Гэр хорооллыг төвлөрсөн ус хангамжид холбох, Цагдаагийн хэлтсийн гадна шугам, Спортын ордны дотор сантехникийн засвар угсралтын 47,2 сая төгрөгийн ажлыг тусгай зөвшөөрлийн хүрээнд хийж гүйцэтгэсэн.



Гэр хорооллын шугам угсралтын ажил



Цагдаагийн хэлтсийн гадна шугам угсралтын ажил

Ажиллагсдын дунд ажлын байраа тохижуулах аян зохион байгуулж өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан бүх ажлын байрууд тохижилт цэцэгжүүлэлтийн ажил хийсэн.







### Ажилчдын нийгмийн асуудлаар

Ажиллагсдын өмнө тулгамдсан нийгмийн асуудлыг сайжруулахад 47.6 сая төгрөгийг зарцуулж дараахь ажлуудыг шийдвэрлэсэн.

- ✓ Олон жил үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллаж байгаа ажилтанд орон сууцны дэмжлэг үзүүлэх арга хэмжээг эхлүүлсэн.
- ✓ Нийт ажилтнуудад халаалтын улирлын хөнгөлөлт үзүүлсэн.
- ✓ Өндөр насны тэтгэвэрт гарч буй ажилтанд олгох нэг удаагийн тэтгэмжийг салбарын хамтын гэрээнд заасан хэмжээнд ойртуулан нэмэгдүүлсэн.
- ✓ Тус компаний байгуулагдснаас хойш өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудад ахмадын баяраар нэг удаа 100,0 мянган төгрөгийн тэтгэмж олгодог болгосон.
- ✓ Ажиллагсдын цалинг 2 удаа тус бүр 50,0 мянган төгрөгөөр буюу үндсэн цалин нийт 14,9 хувиар нэмэгдүүлсэн.
- ✓ Ажиллагсдын хоолны мөнгийг 2 дахин нэмэгдүүлж 2000 төгрөг болгосон.

2017-2020 онд хэрэгжүүлэхээр *"Инновацийг нэвтрүүлж, чанартай бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг найдвартай ханган, өртөг зардлыг бууруулах"* зорилго дэвшүүлэн 7 зорилт төлөвлөн ажиллаж байгаагаас 2017-2018 онд 6 ажил хийгдэж хэрэгжээд байна.

- ✓ Шарын гол сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан дулаан болон ус хангамжийн эх үүсвэр, шугам хоолойг өргөтгөх, шинэчлэх
- ✓ Орон сууцны байруудыг зуны улиралд хэрэгцээний халуун усаар хангах
- ✓ Насосны станцуудыг хувьсах горимд шилжүүлэх
- ✓ Дулааны сүлжээний гидравлик горимыг оновчтой тооцож, тохируулгыг чанартай гүйцэтгэх
- ✓ Гэр хорооллын ус түгээх худгуудыг 24 цагийн ажиллагаатай ухаалаг системтэй ус түгээх байр болгох
- ✓ Таван давхар орон сууцны хэрэгцээний халуун, хүйтэн усны босоо шугам шинэчлэх, хэрэглэгчдийн тоолуурыг төвлөрүүлэх
- Диспетчерийн шуурхай удирдлагад хяналт, мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх